

БАТЛАВ  
БОР-ӨНДӨР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

Г.АДЬЯАБИЛЭГТ

2025.01.24

**БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**БОР-ӨНДӨР СУМАНД “ГЭРЭЛТҮҮЛЭГ”-ЫН АЖЛЫН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
БАРИМТ БИЧИГ**

Төндер  
шалгаруулалтын  
нэр:

Төндер  
шалгаруулалтын  
дугаар:

БОР-ӨНДӨР СУМАНД ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ

**ХЭАБӨСЗДТГ/20250101028**

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА.....	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ.....	15
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	19
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ.....	24
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ.....	27

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### Тендерийн цар хүрээ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

#### Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

#### Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.

#### Худалдан авах ажиллагааны цахим систем

Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

#### Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

#### Сонирхогч этгээд,

Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар

## **оролцогчид тавигдах ерөнхий шаардлага**

үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **Б.АГУУЛГА**

### **Тендер шалгаруулалтын баримт бичиг**

Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах

шаардлага;  
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;  
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;  
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

#### **Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 0-д заасныг мөрдөнө.

#### **Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

ТШЗ-ны 0-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

#### **Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн

авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

## **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

### **Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

Хэрэв ТШЗ-ны 0-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

ТШЗ-ны 0-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

ТШЗ-ны 0-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

оролцогч ТШЗ-ны 0-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 0, 0, 0-д заасан шаардлага, шалгуур

### **Тендерийн иж бүрдэл**

үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;  
санал болгож буй ажил ТШЗ-ны 0-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;  
ТШЗ-ны 0-д заасан ажлын төсөв;  
ТШЗ-ны 0-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;  
Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

Оролцгчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

ТШЗ-ны 0-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

Захиалагч оролцгчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 0, 0-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад

## **Тендерийн жишиг маягтууд**

### **Хувилбарт санал**

### **Ерөнхий шаардлагыг маягдах баримт бичиг**

нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 0, 0-т заасан баримт бичиг ирүүлнэ.

### **Чадавхын болон туршлагын шаардлага**

Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

### **Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

### **Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

ТШЗ-ны 0-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ

### **Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

### **Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

#### **Тендерийн валют**

Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

#### **Тендер хүчинтэй байх хугацаа**

Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 0-д заасан хугацааг сунгаж болно.

Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 0-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

#### **Тендерийн баталгаа**

Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

#### **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

##### **Тендер баталгаажуулах, илгээх**

Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан

тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 0-т зааснаар илгээнэ.

ТШЗ-ны 0-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 0-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 0-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

#### **Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

#### **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

##### **Тендерийн талаар тодруулга авах**

Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

##### **Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 0-т заасан тендерийн иж бурдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

##### **Тендерийг үнэлэх**

Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд

заасны дагуу үнэлж, харьцуулна.

Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

#### **Арифметик алдааг залруулах**

Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

ТШЗ-ны 0-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

#### **Давуу эрх олгох**

Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.

ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.

#### **Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**

Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

#### **Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**

Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.

ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.

ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

#### **Тендерийг эрэмбэлэх**

Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.

#### **Оролцогчийн чадавхыг дахин магадлах**

Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний

мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.

ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

<b>Шийдвэр хүргүүлэх</b>	Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
<b>Гүйцэтгэлийн баталгаа</b>	Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
	Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
<b>Урьдчилгаа төлбөр</b>	Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
	Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 0-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
	Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
	Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
<b>Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах</b>	Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТШЗ-НЫ холбогдох заалт</b>	<b>А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
ТШЗ Error! Reference source not found.	<p>Захиалагчийн нэр: <b>Бор-Өндөр сумын Засаг дарга</b></p>
ТШЗ	<p>Зарлалын дугаар: <b>ХЭАБӨСЗДТГ/20250101028</b></p> <p>Тендер шалгаруулалтын нэр: <b>Бор-Өндөр сумын Холбоо 2-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Гэрэлтүүлэг”-ийн ажил</b></p> <p>Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: <b>багцтай,</b>  <b>Багц-1 - Гэрэлтүүлгийн ажил 1,2,4 баг</b>  <b>Багц-2 - Бумбат 3-р багийн Хайрханы гудамжуудад гэрэлтүүлгийн ажил хийх</b></p>
ТШЗ Error! Reference source not found.	<p>Санхүүжилтийн эх үүсвэр: <b>Хэнтий аймгийн Орон нутгийн хөгжлийн сан</b></p> <p><b>Нийт төсөвт өртөг: 275,185,900</b> (хоёр зуун далан таван сая зуун наян таван мянга есөн зуун)төгрөг</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ <b>Багц:1 төсөвт өртөг: 177.862.100</b> (зуун далан долоон сая найман зуун жаран хоёр мянга нэг зуу) төгрөг</li> </ul> <p><b>Багц 1 - төсөвт өртөгт:</b>Захиалагчийн хяналтын зардал: 3,076,723  Инженер хайгуул, Зураг төслийн ажлын зардал: 7,000,000  Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: 1538,362</p> <p>Магадлашгүй ажил 2%- 3.076.723 дээрх зардлууд төсөвт багтсан болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ <b>Багц:2 төсөвт өртөг : 97,323, 800</b> (ерэн долоон сая гурван зуун хорин гурван мянга найман зуу) төгрөг</li> </ul> <p><b>Багц 2 - төсөвт өртөгт:</b>Захиалагчийн хяналтын зардал: 1,689,943  Инженер хайгуул, Зураг төслийн ажлын зардал:0  Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: 844,972</p> <p>Магадлашгүй ажил 2%- 1,689,943 тус тус зардлууд багтсан байна.  <b>Дээрх зардлууд нийт төсөвт өртөгт багтсан болно.</b></p>

### **Б.АГУУЛГА**

ТШЗ 9.2	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан:ЗДТГ-ын мэргэжилтэн А.Өлзийсүрэн Хаяг: <b>Хэнтий аймаг, Бор-Өндөр сум,Холбоо 2-р баг, ЗДТГазар</b> Утасны дугаар: <b>70567143</b> Цахим шуудан: <b>borondorzdtg@gmail.com</b>
ТШЗ	Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: <b>“ҮГҮЙ”</b>
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
ТШЗ	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ	Хувилбарт санал ирүүлэхийг <b>“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”</b>
ТШЗ 14	Тендерийн баталгаа: <b>“ШААРДАНА”</b> /Төсөвт өртгийн 0,5 хувиар тогтооно./

ТШЗ	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг: <b>хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангагүй гэж үзнэ.</b>																																													
ТШЗ	<p>Санхүүгийн чадавхын шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 3 жилийн Санхүүгийн тайлан</li> <li>- Борлуулалтын орлогын хэмжээ: Гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн [100%] хувиас багагүй байх.</li> <li>- Түргэн хөрөөх хөрөнгөтэй холбогдох шаардлага /төсөөт өртөгийн 50% дээш байх /</li> </ul>																																													
ТШЗ	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p><b>Холбогдох хууль, журмын дагуу хянан үзнэ.</b></p>																																													
ТШЗ	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: [<b>“Шаардана”</b> <b>Ажил гүйцэтгэх хүний нөөц “шаардана”</b>]</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>No</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил</th> <th>Диплом, гэрчилгээний хуулбар ирүүлэх шаардлагатай эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td><b>Мэргэшсэн инженер</b></td> <td>1</td> <td>3-аас доошгүй жил</td> <td><b>Цахилгааны инженер</b></td> <td><b>Мэргэшсэн зэргийн гэрчилгээ ирүүлэх</b></td> </tr> <tr> <td>2</td> <td><b>Инженер</b></td> <td>1</td> <td>3-аас доошгүй жил</td> <td><b>Барилгын инженер</b></td> <td><b>Холбогдох баримт бичиг ирүүлэх</b></td> </tr> <tr> <td>4</td> <td><b>Мэргэжлийн төсөөчин</b></td> <td>1</td> <td>3-аас доошгүй жил</td> <td><b>төсөөчин</b></td> <td rowspan="4"><b>Холбогдох баримт бичиг ирүүлэх</b></td> </tr> <tr> <td>5</td> <td><b>ХАБЭА ажилтан</b></td> <td>1</td> <td>3-аас доошгүй жил</td> <td><b>ХАБЭА ажилтан</b></td> </tr> <tr> <td>6</td> <td><b>Барилгын ажилтан</b></td> <td>3-5</td> <td>3-аас доошгүй жил</td> <td></td> </tr> <tr> <td>7</td> <td><b>Цахилгаанчин</b></td> <td>1-2</td> <td>3-аас доошгүй жил</td> <td><b>Цахилгаанчин</b></td> </tr> <tr> <td>8</td> <td><b>Бусад ажилчид</b></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> <li>• Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж, тухайн төсөлт арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.</li> <li>• Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж, тухайн төсөлт арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.</li> <li>• Дээрх инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байрисан эсэхийг лавлах шаардлагатай.</li> <li>• Уйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана</li> </ul>	No	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, гэрчилгээний хуулбар ирүүлэх шаардлагатай эсэх	1	<b>Мэргэшсэн инженер</b>	1	3-аас доошгүй жил	<b>Цахилгааны инженер</b>	<b>Мэргэшсэн зэргийн гэрчилгээ ирүүлэх</b>	2	<b>Инженер</b>	1	3-аас доошгүй жил	<b>Барилгын инженер</b>	<b>Холбогдох баримт бичиг ирүүлэх</b>	4	<b>Мэргэжлийн төсөөчин</b>	1	3-аас доошгүй жил	<b>төсөөчин</b>	<b>Холбогдох баримт бичиг ирүүлэх</b>	5	<b>ХАБЭА ажилтан</b>	1	3-аас доошгүй жил	<b>ХАБЭА ажилтан</b>	6	<b>Барилгын ажилтан</b>	3-5	3-аас доошгүй жил		7	<b>Цахилгаанчин</b>	1-2	3-аас доошгүй жил	<b>Цахилгаанчин</b>	8	<b>Бусад ажилчид</b>				
No	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, гэрчилгээний хуулбар ирүүлэх шаардлагатай эсэх																																									
1	<b>Мэргэшсэн инженер</b>	1	3-аас доошгүй жил	<b>Цахилгааны инженер</b>	<b>Мэргэшсэн зэргийн гэрчилгээ ирүүлэх</b>																																									
2	<b>Инженер</b>	1	3-аас доошгүй жил	<b>Барилгын инженер</b>	<b>Холбогдох баримт бичиг ирүүлэх</b>																																									
4	<b>Мэргэжлийн төсөөчин</b>	1	3-аас доошгүй жил	<b>төсөөчин</b>	<b>Холбогдох баримт бичиг ирүүлэх</b>																																									
5	<b>ХАБЭА ажилтан</b>	1	3-аас доошгүй жил	<b>ХАБЭА ажилтан</b>																																										
6	<b>Барилгын ажилтан</b>	3-5	3-аас доошгүй жил																																											
7	<b>Цахилгаанчин</b>	1-2	3-аас доошгүй жил	<b>Цахилгаанчин</b>																																										
8	<b>Бусад ажилчид</b>																																													

	<ul style="list-style-type: none"> <li>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: Шаардана Ижил төстэй үйлчилгээг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: 2024, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дунтэй ижил төстэй үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх.</li> </ul> <p>/ Үйлчилгээг гүйцэтгэсэн гэрээ, комисс хүлээж авсан дүгнэлт, тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл ирүүлнэ. Тус мэдээллийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</p>
ТШЗ	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага [“Шаардана”] [ӨХ 18.1-д заасан шаардлагыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичгийг хуулийн 17.2-т заасан баримт бичгийн дагуу ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шаардсан хүний нөөцийг мэдээллийт V бүлгийн маягтын дагуу ирүүлэх;</li> <li>- Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн сүүлийн 2 жилийн хугацаанд ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</li> <li>- Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт);</li> </ul> <p>Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.]</p>
ТШЗ	<ul style="list-style-type: none"> <li>- Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: <b>[Шаардана ]</b></li> <li>- Барааны хувьд эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ</li> <li>- Нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт эсхүл гэрэл зураг, тэдгээрийн үнэн болохыг гэрчилсэн баримт бичиг</li> </ul> <p>- Гарал үүслийн бичиг зэрэг, шаардлагатай бичиг баримтууд Барааны гарал үүслийн гэрчилгээг ирүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Барааны чанарын сертификатыг монгол хэл дээр ирүүлэх;</li> <li>- Гэрэлтүүлэг, шон зэрэг барааны каталоги танилцуулга, фото зураг ирүүлэх;</li> <li>- Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлэх.</li> <li>- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана;</li> </ul>
ТШЗ	<p>Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: <b>“ТИЙМ”</b></p> <p>Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэх эсэх: <b>“ТИЙМ”</b></p> <p>Нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой бусад шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 12 сараас доошгүй сарын баталгаат хугацаатай байна. Баталгаат хугацаанд ашиглалтын буруугаас үүссэн эвдрэл гэмтлээс бусад эвдрэл гэмтэл, мөн элэгддэг сэлбэг, эд ангийг бүрэн хариуцах</li> </ul>
ТШЗ	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“ТОХИРУУЛАХГҮЙ”</b>

<b>ТШЗ Error! Reference source not found.</b>	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “ҮГҮЙ”
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>ТШЗ Error! Reference source not found.</b>	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <b>[ТШЗ -т зааснаас бусад ил болгох баримт бичгүүдийг жагсаан бичнэ.]</b>
<b>ТШЗ</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь          Тендерийг 2025 оны 02-р сарын 24-ны өдрийн 10 цаг 00 минут–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2025 оны 02-р сарын 24-ны өдрийн 10цаг 30 минут-д нээнэ.</p>
	<p><b>Тусгай зөвшөөрөл: шаардана</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>-T3-2.1 0.4-15кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил,</b></li> </ul>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### Багц -1 “Гэрэлтүүлгийн ажил 1,2,4 баг” техникийн тодорхойлолт

Хөнтний аймгийн Бор Өндөр сүм

Гэр хороолол, авто замын гэрэлтүүлэс

#### АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

13М УРТТАЙ ШОНТОЙ ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ			
Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гэрэлтүүлгийн шонгийн цэг тэмдэгдэж гадас зох	1тулгу-ур	3
2	13м урттай гэрэлтүүлгийн цамхаг утсарч босгох	ширхэг	3
3	ЛЭД гэрэлтүүлэгчийг цамхагт сууринуулах, гэрэлтүүлэгчийн чадал 150ват	ш	18
4	Фаз салбарлагч угсрал JBC-1	ш	6
5	Газардуулын салбарлагч угсрал JBC-0	ш	4
6	22 мм голчтой бөөрөхий темэр газардуулагчийг гар ажилгаагаар зох	ш	48
7	Газардуултын 40*4 шинийг шуудуунд угсрал	м	180
8	Гэрэлтүүлгийн тулгуурт газардуултын буулт хийх	1 тулгу-ур	3
9	Темэр шон, хөндлөвчийг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	тонн	1.65
10	Дамартай утас, трсыг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	тонн	0.1
11	Тоопуурын хайрцааг бетон тулгуурт бэхлэх	ширхэг	1
12	З фазын тоолуур угсрал	ш	2
13	Гэрэлтүүлгийн шонгийн бетон суурь цутгах В20	м3	8.64
14	Бетон ба дэвсгэр үеийг арматурулах	тн	0.162
15	Тупах бутгац дээр анкерын болот суулган бетондох	тн	0.095
16	Бетонд үлдэх ган бутгээцийг байрлуулах	тн	0.059
17	Газардуултын шуудуу механизмаар ухах	м3	36.67
18	Газардуултын шуудуу гарцаар ухах	м3	1.13
19	Газардуултын шуудуут механизмаар хөрсийг түрж хүнхэл ба шуудууг булах	м3	30.52
20	Газардуултын шуудуу 2-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	м3	5.39
21	Гэрэлтүүлгийн шонгийн сууриний нүхийг эксиковатороор 3-р зэргийн хөрсийг ухаж овоюлох	м3	22.32
22	Гэрэлтүүлгийн шонгийн сууриний нүхийг 3-р зэргийн хөрсөнд гарцаар ухах	м3	1.68
23	Гэрэлтүүлгийн шонгийн сууриний нүхийг хөрсөөр түрж булах	м3	16.32
24	Тулгуурын нүхийг гарцаар булах	м3	2.88
ЧАГТАН СУҮРТТАЙ ГЭРЭЛТҮҮЛЭГ			
Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гэрэлтүүлгийн шонгийн сууриний нүхийг 3-р зэргийн хөрсөнд гарцаар ухах	м3	7.92
2	Тулгуурын нүхийг гарцаар булах	м3	6.336
3	Газардуултын шуудуу механизмаар ухах	м3	18.72
4	Газардуултын шуудуут механизмаар хөрсийг түрж хүнхэл ба шуудууг булах	м3	17.784
5	Гэрэлтүүлгийн шонгийн цэг тэмдэгдэж гадас зох	1тулгу-ур	22
6	Гадна талбайн 1 толгойтой темэр шонтой гэрэлтүүлэгч угсрал	ш	22
7	Гэрэлтүүлгийн салбарлагч угсрал	ш	22
8	Сип утасны фазын салбарлагч Ild-181 угсрал	ш	22
9	Тулгуурт баригч сүүлгах	ш	18
10	Тулгуурт татагч сүүлгах	ш	2
11	Гэрэлтүүлгийн тулгуурт газардуултын буулт хийх	1 тулгу-ур	6
12	22 мм голчтой бөөрөхий темэр газардуулагчийг гар ажилгаагаар зох	ш	39
13	Газардуултын 40*4 шинийг шуудуунд угсрал	м	91
14	0.4 кв-ын агаарын шугамын бүрээстэй 3x16+1x54 мм2 сип утас завсрлын тулгуурт татах	км	0.82635
15	Гэрэлтүүлгийн шонд татуурга хийх	1тулгу-ур	4
16	Татлагын хавтан сууринуулах.	ширхэг	4
ГЭРЭЛТҮҮЛГИЙН САМБАРЫН АЖИЛ			
Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

1	Гадна гэрэлтүүлгийн удирлагын самбар IP-65 угсрах	ширхэг	1
2	Гэрэлтүүлгийн самбарын бетон суурь угсрах	ш	1
3	3 фазын тоолуур угсрах	ш	1
4	22 мм голчтой бөөрөнөй темер газардуулагчийг гар ажилгаалаар зох	ш	16
5	Газардуулгын 40*4 шинийг шуудуунд угсрах	м	60
6	Гэрэлтүүлгийн самбарын суурин нүхийг экскаватороор 3-р зэргийн хөрсийг ухаж овоолох	мз	8.4
7	Гэрэлтүүлгийн самбарын суурин нүхийг хөрсөвр түрж булах	мз	6.72
8	Гэрэлтүүлгийн самбарын газардуулгын шуудууны ба сувалгзэний нүх механизмаар ухах	мз	28.8
9	Газардуулгын шуудуут механизмаар хөрсийг түрж хүнхээл ба шуудуут булах	мз	26.28

## БЕТОН СУУРЬТАЙ ГЭРЭЛТҮҮЛЭГ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гэрэлтүүлгийн шонгийн суурин нүхийг экскаватороор 3-р зэргийн хөрсийг ухаж овоолох	мз	10.2
2	Гэрэлтүүлгийн шонгийн суурин нүхийг 3-р зэргийн хөрсөнд гарцаар ухах	мз	
3	Гэрэлтүүлгийн шонгийн суурин нүхийг хөрсөвр түрж булах	мз	8.16
4	Тулгуурын нүхийг гарцаар булах	мз	
5	Гэрэлтүүлгийн шонгийн цэг тэмдэгдэж гадас зох	1тулгу-ур	34
6	Гэрэлтүүлгийн шонгийн бетон суурь угсрах	ш	34
7	Гадна талбайн 1 толгойтой темер шонтой гэрэлтүүлэгч угсрах	ш	34
8	Гэрэлтүүлгийн салбарлагч угсрах	ш	34
9	Гаргалгын рубильник угсрах 250A	ш	1
10	Гал хамгаалагчид утсыг холбон залгаж ажиллуулахад бэлтгэх, гүйдлийн хуч 100а-хүртэл	ш	3
11	Темер шон, хөндлөвчийг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	тонн	6.46
12	Дамартай утас, тросыг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	тонн	0.1

## ГЭРЭЛТҮҮЛГИЙН ШОНГИЙН КАБЕЛЬ ШУГАМЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Кабелийн шуудуу механизмаар ухах	мз	347.58
2	Кабелийн шуудуут механизмаар хөрсийг түрж хүнхээл ба шуудуут булах	мз	330.2
3	0,4кВ-ын АВВБ 3*35+1*16мм <sup>2</sup> гэрэлтүүлгийн самбар хүртэлх тэжээлийн кабелийг шуудуунд сунгах	м	188
4	0,4кВ-ын АВВБ 3*35+1*16мм <sup>2</sup> гэрэлтүүлгийн самбар хүртэлх тэжээлийн кабелийг тулгуураар сунгах /самбар луу орох/	м	15
5	0,4кВ-ын АВВБ 3*35+1*16мм <sup>2</sup> гэрэлтүүлгийн самбар хүртэлх тэжээлийн кабелийг холойд сунгах	м	10
6	0,4кВ-ын АВВБ 3*16+1*25мм <sup>2</sup> гэрэлтүүлгийн шон хүртэлх тэжээлийн кабелийг шуудуунд сунгах	м	1700
7	0,4кВ-ын АВВБ 3*16+1*25мм <sup>2</sup> гэрэлтүүлгийн шон хүртэлх тэжээлийн кабелийг тулгуураар сунгах /самбар луу орох/	м	68
8	0,4кВ-ын АВВБ 3*16+1*25мм <sup>2</sup> гэрэлтүүлгийн шон хүртэлх тэжээлийн кабелийг тулгуураар сунгах /тулгуураас буух/	м	144
9	0,4кВ-ын АВВБ 3*16+1*25мм <sup>2</sup> гэрэлтүүлгийн шон хүртэлх тэжээлийн кабелийг холойд сувлэж тавих	м	10
10	50мм голчтой ган холойг угсрах	1 м холой	10
11	25мм <sup>2</sup> хүртэл огтлолтой кабелийн судсанц тэгсгэвч шахах	ш	14
12	16мм <sup>2</sup> хүртэл огтлолтой кабелийн судсанц тэгсгэвч шахах	ш	14
13	Тэгсгэлийн муфты угсрах /35-50мм/ 0.4 кв	ш	
14	Тэгсгэлийн муфты угсрах /16-35мм/ 0.4 1кв	ш	4
15	Дулааны ўйлчлэлээр агшдаг холбогтын муфты угсрах /35-50мм/ 0.4кв	ш	
16	Элсэн дэвсгэр эхний кабельд хийх	м	635

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

17	Тоосгон хүчилтээ зүйний кабельд хийх	м	635
18	Сувагчлалын болон газрын кабельд хамгаалалтын түүз дэвсэх	км	0.635
19	Авто замын доорх далд хэвтээ аргаар өрөмдөж ган хоолой Ф50мм угсралт /ган яндан 10m/	1 яндан	1

**Багц:2 Бумбат 3 дугаар багийн Хайрханы гудамжуудад гэрэлтүүлэг хийх” ажлын техникийн тодорхойлолт**

**Энэхүү багцийн ажлын зураг байхгүй болно.**

Бор-өндөр сумын ЗДТГазар

Гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Бор-Өндөр/

**АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

**ГАДНА ГЭРЭЛТҮҮЛЭГ, БУСАД КАБЕЛЬ ШУГАМЫН АЖИЛ /БОР-ӨНДӨР/**

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	0.4 кв-ын агаарын шугамын бүрээстэй 4x16+1x25мм2 СИП утас завсрын тулгуурт татах	км	1.92
2	0.65м3 багтаамжтай шанагат эксковатороор 2-р зэргийн херсийг ухаж овоолох	м3	58.8
3	2-р зэргийн хөрсөнд гараар ухах	м3	4.11
4	Шуудуу эргүүлж булах	м3	50.121
5	90 морины хүчтэй бульдозероор 1-р зэргийн херсийг 10 м зайд түрэх	м3	58.8
6	Х/ц голтой, кабельийг шуудуунд сунгах АВВБ 4x16мм2	м	
7	Х/ц голтой, кабельийг шуудуунд сунгах АВВБ 4x10мм2	м	210
8	Сувагчлалын болон газрын кабельд хамгаалалтын тууз дэвсэх	км	0.35
9	Элсэн дэвсгэр эхний кабельд хийх	м	210
10	Тоосон хүчинтэй эхний кабельд хийх	м	210

**ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ /БОР-ӨНДӨР/**

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гэрэлтүүлгийн шонгийн суурийн нүх гараар ухах	м3	18.81
2	Гэрэлтүүлгийн шонгийн бетон суурь цутгах	м3	12.72
3	Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч угсралт /8м, 150Вт чадалтай лед гэрэлтүүлэгчтэй/	ш	48
4	Шонд цацуулагч хуулга наах	м2	6
5	Гэрэлтүүлгийн самбар угсралт ГГС	ком	1

**ГЭРЭЛТҮҮЛГИЙН ШОНГИЙН ГАЗАРДУУЛГЫН АЖИЛ /БОР-ӨНДӨР/**

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	2 м хүртэл гүн шуудууг бэхэлгээгүйгээр 2-р зэргийн хөрсөнд гараар ухах	м3	33.8
2	Шуудуу хүнхээл нүхийг 1-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	м3	17.08
3	40х4мм2 хүртэл отглолтой газардуулгын шинийг шуудуунд угсралт	м	288
4	50*50*5мм хэмжээтэй булан төмөр газардуулагчыг гар ажилгаагаар зоох	ш	96

**ГЭРЭЛТҮҮЛГИЙН САМБАРЫН ГАЗАРДУУЛГЫН АЖИЛ /БОР-ӨНДӨР/**

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	2 м хүртэл гүн шуудууг бэхэлгээгүйгээр 2-р зэргийн хөрсөнд гараар ухах	м3	3
2	Шуудуу хүнхээл нүхийг 1-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	м3	1.8
3	40х4мм2 хүртэл отглолтой газардуулгын шинийг шуудуунд угсралт	м	20
4	50*50*5мм хэмжээтэй булан төмөр газардуулагчыг гар ажилгаагаар зоох	ш	8

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)	
1	2	3	4	5	6	7	
1	[Барааны нэрийг бичих]	[Нэгжийн тоо ширхгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор нийлүүлэх	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]	
2							
3							
...							

#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ**

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөх шаардлагатай бүх маягтыг тусгана.

##### **Маягтын жагсаалт:**

<b>Маягт 1: Тендер илгээх маягт.....</b>	<b>25</b>
<b>Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл.....</b>	<b>26</b>
<b>Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл .....</b>	<b>26</b>
<b>Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл .....</b>	<b>26</b>
<b>Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт .....</b>	<b>26</b>

## Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

### Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 3.1. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна<sup>1</sup>
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догодолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг мэдээлэл:**

**Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

## V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдэхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохиорох үг өгүүлбэр, too хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### Тодорхойлолт

#### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
- 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
  - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
  - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
  - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
  - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
  - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
  - 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн

гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

## Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

### Бараа нийлүүлэх

2.1. Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй

2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна

2.3. ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.

2.6. Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.

2.7. Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

2.7.1. Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.7.2. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.

2.8. Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

### Бараа нийлүүлэх газар

### Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах

<b>Барааг хүлээлгэн өгөх</b>	2.9. ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй. 2.10. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. 2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ. 2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
<b>Баглаа боодол</b>	2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ. 2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө. 2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. 2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
<b>Худалдааны нөхцөл</b>	<b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b>
<b>Барааг хүлээн авах</b>	3.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. 3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ. 3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. 3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна. 3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй. 3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна. 3.7. Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
<b>Гэрээний үнэ</b>	

		3.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
Төлбөр төлөх		3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
		3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
		3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
		3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
		3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
		3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
		3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.
		<b>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</b>
Захиалагчийн эрсдэл	хүлээх	<p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p>
Даатгал		<p>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.</p>
Доголдол		<p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p> <p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p> <p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</p> <p>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p> <p>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа</p>

	хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
Чанарын баталгаа	<p>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэrsэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p>
Алданги	<p>4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
Оюуны өмчийн эрх зөрчих	<p>4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгaa өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p>
Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал	<p>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгaa, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p> <p>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p>
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	

4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасны зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

#### **ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ**

##### **Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл**

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.

5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

#### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

##### **Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл**

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын догоилдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.

6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас

##### **Туслан гүйцэтгэгч**

##### **Нууцлал**

**Мэдэгдэл**

бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсандаа тооцно:

6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:

6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;

6.15.2. үнийн тохируулга хийсэн.

6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах****Маргаан шийдвэрлэх**

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 4.1.</b>	Ажил эхлэх хугацаа: <b>2025.03.25</b>
<b>ГЕН 4.2.</b>	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <b>2025.03.25</b>
<b>ГЕН 4.9.</b>	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <b>шалгарсан компани ажлын явцын тайлан болон ил болон далд үеийн тайланг ирүүлэх</b>
<b>ГЕН 5.2.</b>	Үнийн тохируулга: <b>хийхгүй</b>
<b>ГЕН 5.4.</b>	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>ГЕН 6.8.</b>	<b>Чанарын баталгаа:</b> Чанарын баталгаа шаардах эсэх: <b>Чанарын баталгаа шаардана</b> <b>Чанарын баталгаа шаардах бол,</b> <b>Чанарын баталгааны хэмжээ: [Гэрээний үнийн дунгийн 5 хувийн хооронд сонго.]</b>
<b>ГЕН 6.14.</b>	Баталгаат хугацаа: <b>Барилгын тухай хуулийн дагуу</b>
<b>ГЕН 7.5.</b>	Даатгал: <b>Ажилчид гэнэтийн ослын даатгалд хамрагдсан байх</b>
<b>ГЕН 10.21.</b>	<b>Захиалагчийн төлөх алдангийн хувь:</b> Алдангийн хувь: <b>[ хоног тутамд 0.5 хүртэл хувиар</b>
<b>ГЕН 10.22.</b>	<b>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:</b> Алдангийн хувь: <b>[ хоног тутамд 0.5 хүртэл хувиар</b>

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

..... хот/аймаг

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Техникийн тодорхойлолт;
  - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

